



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/297

Арвайхээр

**Хөрөнгө зарцуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “б”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/10 дугаар “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” тогтоолын хоёрдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/10 дугаар “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” тогтоолын хоёрдугаар хавсралтыг 1.8-д (Нийтийн орон сууцны засвар, дээврийн засвар) батлагдсан эх үүсвэрээс Арвайхээр сумын 5 дугаар багийн 454, 455 дугаар байрнуудын гадна фасадны засварт 60,000,000 (жаран сая) төгрөг зарцуулсугай.

2. Дээрх төсөл хөтөлбөрийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100697